



## НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А/дЗ

Улаанбаатар хот

### Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалт, Байгууллагын үйл ажиллагааны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.8 дахь хэсэг, 2024 оны Захиргааны зөвлөлийн 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын 2024 оны төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, өөрийн орлогыг давуулан биелүүлсэн тул ашиглалтад ороод 20 жил болж өнгө үзэмж нь муудсан их танхимын хивсэнцэр авах зардлыг гаргасугай.

2. Хивсэнцрийг шинэчлэх зардал 41,400,000 (дөчин нэгэн сая дөрвөн зуун мянга) төгрөгийг урсгал засварын зардлаас зарцуулахыг Ерөнхий нягтлан бодогч (Ө.Цолмон)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн ажилтан (Ч.Хишигсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ  Л.АРИУНТУЯА



9023 1029 9107959